



ДОРНОД АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 08 сарын 04 өдөр

Дугаар А/25

Чойбалсан

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.1 дүгээр заалт, Эрүүл мэндийн сайдын 2014 оны А/358, 2018 оны А/438, 2020 оны А/482 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны А/04 албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Томуу, томуу төст өвчний бэлэн байдлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай


2.Томуу, томуу төст өвчний бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга /Б.Сарнай/, Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга /Ч.Оюунтунгалаг/ нарт үүрэг болгосугай

3.Тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.

4.Төлөвлөгөөний хэрэгжилтийг 10 дугаар сарын 01-нээс, 06 дугаар сарын 01-ний хооронд сар бүрийн 21-нд Нийгмийн эрүүл мэндийн төвд ирүүлэхийг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, эдийн засаг, мэдээллийн хэлтсийн дарга /Я.Эрдэнэтуяа/, хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын ахлах мэргэжилтэн /Б.Гантуяа/ нарт даалгасугай.

ДАРГА



Ч.ОЮУНАА

Эрүүл мэндийн газрын даргын оны
 В.Б. дугаар сарын ...~~08~~ны/ний өдрийн
 #23 Дугаар/дүгээр тушаалын
 хавсралт

9031774 Ж. 07.19.110008

ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДАЛ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭГ
 ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран ажиллах байгууллага
I ҮЕ ШАТ. ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ УЛИРАЛ ХООРОНДЫН ҮЕ /амбулаторийн үзлэгт ТТӨ-ний 10000 хүн ам дах үзлэг <22.6/ Төлөвлөлт, зохицуулалт				
1	Эрүүл мэндийн сайдын 2014 оны 358, 2018 оны А/438, 2020 оны 482 тоот тушаалыг хэрэгжүүлж ажиллах	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд		
2	ТТӨ-ний хариу арга хэмжээний бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж бэлэн байдлыг хангах	9 дүгээр сард	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	
3	ТТӨ-ний дэгдэлтийн үед ажиллах эмч, мэргэжилтнийг томилон албажуулах, бүртгэх	9 дүгээр сард	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	
4	ТТӨ-ний дэгдэлтийн үед нэмэлтээр ажиллах хувийн эмнэлэгтэй гэрээ байгуулах	9 дүгээр сарын 15-аас 10 дугаар сарын 15	ЭМГ	Хувийн хэвшлийн эмнэлгүүд
5	Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ТТӨ-ий эмнэлзүй удирдамж, /ХӨЦМ, амилуулах, яаралтай тусламж/ тандалт, хариу арга хэмжээ, халдварын хяналт, сэргийлэлт, эрсдэлийн үеийн харилцаа холбооны чиглэлээр сургалт зохион байгуулах	9 дүгээр сарын 23-аас	ЭМГ	БОЭТ, СЭМТ, ӨЭМТ
Тандалт, халдвар хяналт				
1	ТТӨ-ний тандалтыг долоо хоног бүр хийж, эргэн мэдээллээр хангах	7 хоног бүр	ЭМГ	Харуулдан тандалтын нэгжүүд

2	Улирлын томуугийн вакцинд хамрагдах эрсдэлт бүлгийн хүн амын судалгаа гаргах	9 дүгээр сард	ЭМГ	ӨЭМТ, СДЭ, СЭМТ
3	Улирлын томуугийн вакцины тооцоог гаргаж захиалга, түгээлт хийх	9 дүгээр сард	ЭМГ	ӨЭМТ, СЭМТ
4	Улирлын томуугийн хүндрэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зорилтот бүлгийн 700 хүүхдийг Орон нутгийн хөгжлийн сангийн дэмжлэгтэйгээр үнэ төлбөргүй томуугийн вакцинд хамруулах	9-10 дугаар сард	ӨЭМТ, СЭМТ	ЭМГ
5	Эмч эмнэлгийн ажилтнуудаа амин дэмээр хангах, дархлаажуулалтад хамруулах	9-10 дугаар сард	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	
6	Сургуулийн өмнөх боловсрол олгох байгууллагуудад дэмжлэгт хяналт хийн, хүүхдийн байгууллагад мөрдөгдөж буй тушаал, зааврын хэрэгжилтийг үнэлж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх	9 дүгээр сарын 10-аас 10 дугаар сар	Эрүүл мэндийн газар	
7	Эрүүл мэндийн байгууллага дээр, үйлчлүүлэгсдийн гар халдваргүйжүүлэх, угаах нөхцлийг бүрдүүлэх	9 дүгээр сард	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	
8	Үйлчлүүлэгч бүрт амны хаалт хэрэглүүлж хэвших	Тухай бүр	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	
Эмнэлгийн тусламж, үйлчилгээ				
1	Шаардлагатай эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, хэрэгцээний судалгаа гаргах, бэлэн байдлыг хангах	10 дугаар сарын 01-ний дотор	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	ЭМГ
2	Лабораторийн оношлуур, урвалж бодис, жижиг хэрэгслийн тооцоог гаргаж, бэлэн байдлыг хангах	9 дүгээр сард	БООТ	ЭМГ
3	Хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисын хэрэгцээг тооцож нөөцлөх	9 дүгээр сард	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	ЭМГ
4	Эрүүл мэндийн байгууллагууд томуу, томуу тест өвчний улмаас эмнэлэгт хандаж буй үйлчлүүлэгсдийг бусад шалтгаанаар хандаж байгаа үйлчлүүлэгсэдтэй хавьтал болохгүй байх урсгал зохицуулалтыг хийх	Тухай бүр	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	ЭМГ

5	Хоёр дахь хүлээн авах яаралтай тусламжийн тасгийг нээж, томуутай өвчтөнд үзлэг хийж буй газар хэт бөөгнөрөл үүсгэхгүй байх урсгал зохицуулалт хийх бэлтгэл ажлыг хангах	9 дүгээр сард	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	ЭМГ
6	Өрхийн эмчийн хяналтыг сайжруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээг нэн тэргүүнд үзүүлэх бэлтгэл ажлыг хангах	9 дүгээр сард	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	ЭМГ
7	5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэнд, гэрийн эргэлтэд онцгой анхаарч, шатлал, эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэхдээ хүндрэл учруулахгүй байх	Тухай бүрд	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	ЭМГ
8	Эмнэлгийн тусламж үйлчилгээ, амьсгалын замын дуталтай өвчтөнүүдэд шаардлагатай эм бэлдмэл, вирусийн эсрэг, дархлаа дэмжих эмийн нөөцийг нэмэгдүүлэх, бэлэн байдлыг хангах	9 дүгээр сард	БОЭТ	ЭМГ
9	Эмнэлгийн орны ачаалал нэмэгдсэн үед орны зохицуулалт хийх, орны тоог нэмэгдүүлэх, нэмэлт ор, тасаг дэлгэх бэлэн байдлыг ханган ажиллах	Тухай бүрд	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	ЭМГ
10	Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагууд дээр хүн амын хэт бөөгнөрөл үүсэхээс сэргийлж, гэрийн үзлэг, эргэлтийг нэмэгдүүлэх	9 дүгээр сард	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	ЭМГ
Эрсдлийн үеийн харилцаа, холбоо				
1	Хүн амд чиглэсэн мэдээлэл сурталчилгааны материал, санамж зөвлөмж түгээх	9 дүгээр сараас	ӨЭМТ, СЭМТ	ЭМГ
2	Орон нутгийн гэрээт хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт шуурхай түгээх	9 дүгээр сараас	ЭМГ	Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсууд
II ҮЕ ШАТ. ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ИДЭВХИЖЛИЙН ҮЕ /амбулаторийн үзлэг ТТӨ-ний 10000 хүн ам дах үзлэг <22.7-36/ Төлөвлөлт, зохицуулалт				
1	Тандалтын мэдээнд үндэслэн эрсдлийн үнэлгээ хийж, хариу арга хэмжээг зохион байгуулах	Тухай бүр	ЭМГ	БОЭТ

2	Нийгмийн хариуцлагын хүрээнд сургууль, албан байгууллагуудад томуу, томуу тест өвчний хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх	11 дүгээр сарын 10-ны дотор	ЭМГ	МХГ, БСУГ
Тандалт, хяналт				
1	ТТӨ-ий тандалтыг хийж, бүх шатны ЭМБ-ыг эргэн мэдээллээр хангах	7 хоног тутам	ЭМГ	БОЭТ, СЭМТ, ӨЭМТ
2	Хүүхдийн байгууллагад ирцийн тандалт хийх	10-12 дугаар сард	ЭМГ	БСУГ
Эмнэлгийн тусламж, үйлчилгээ				
1	ӨЭМТ-ийн ажлын цагт зохицуулалт хийж, хуваарь гарган, уртасгасан цагаар ажиллуулах	Тухай бүр	ӨЭМТ, СЭМТ	ЭМГ
2	Эрсдэлт бүлгийн хүн амд /жирэмсэн эх, 5 хүртэлх насны хүүхэд, 65-аас дээш насны өндөр настан, архаг хууч өвчтэй хүн/ хийх өрхийн эмчийн үзлэгийн давтамжийг нэмэгдүүлэх	Тухай бүр	ӨЭМТ, СЭМТ	ЭМГ
3	Түргэн тусламжийн машин, эмчийн тоог нэмэгдүүлэх	Тухай бүр	БОЭТ	ЭМГ
4	Үүсгэгчийн онцлогоос шалтгаалж, амьсгалын замын цочмог хүнд халдвартай өвчтний, ялган оношилгооны талаар зөвлөмжөөр хангах, хэрэгжүүлэх	11 дүгээр сард	БОЭТ	ЭМГ, ӨЭМТ, СЭМТ
Эрсдлийн үеийн харилцаа, холбоо				
1	Хүн амд томуугаас урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгаа хийх	10-11 дүгээр сард	ЭМГ	ӨЭМТ, СЭМТ
2	Хүүхдийн байгууллагад тодорхой давтамжтайгаар эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийх, зөвлөгөө өгөх	10-12 дугаар сард	ЭМГ	ӨЭМТ, СЭМТ БСУГ
III ҮЕ ШАТ. ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ АЛАГ ЦООГ ДЭГДЭЛТИЙН ҮЕ /амбулаторийн үзлэгт ТТӨ-ний 10000 хүн ам дах үзлэг <37-70/ Төлөвлөлт, зохицуулалт				
1	Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг нэмэлтээр ажиллуулах шийдвэр гаргах	Тухай бүр	ЭМГ	БОЭТ, ӨЭМТ, СЭМТ
2	Шуурхай удирдлагын нэгж идэвхжиж, тохиолдлын удирдлагын тогтолцоо ажиллаж эхлэх	Тухай бүр	ЭМГ, ШУН, БОЭТ	ӨЭМТ, СЭМТ
Тандалт, хяналт				
1	ТТӨ-ий тандалтыг идэвхжүүлж, эрсдлийн үнэлгээ хийх	Тухай бүр	ЭМГ, ШУН, БОЭТ	ЭМГ, ШУН, БОЭТ
2	Хүүхдийн байгууллагын нягтралыг бууруулах талаар зөвлөмж гаргах	11 дүгээр сард	ЭМГ, ШУН, БОЭТ	ЭМГ, ШУН, БОЭТ

3	Эмнэлгийн эргэлтийн цагийг хязгаарлаж, сахиурын тоог цөөлж, шаардлагагүй тохиолдолд сахиурыг солихгүй байх арга хэмжээ авна.	Тухай бүр	Эрүүл мэндийн байгууллагууд
4	ТТӨ-өөр өвчилсөн өвчтөний үзлэгийн өрөөг эмнэлгийн орох хаалганаас тусдаа хаалгатай, орох гарах хаалгатай ойр, олон хүний хөл хөдөлгөөнөөс зайдуу, агааржуулалт сайтай, гарын угаалтууртай хэсэгт, эмнэлгээр үйлчлүүлж буй бусад үйлчлүүлэгчидтэй хавьтал болохооргүй өрөөг сонгож, амбулаторид нэмэлтээр хөтөч сувилагч ажиллуулж, эмнэлгийн гадна тал, үүдэн хэсэгт “Дуугүй хөтөч” байрлуулна.	Тухай бүр	Эрүүл мэндийн байгууллагууд
Эмнэлгийн тусламж, үйлчилгээ			
1	Өрхийн эмчийн үзлэгийг гэрийн үйлчилгээнд бүрэн шилжүүлэх	Тухай бүр	Сум өрхийн эрүүл мэндийн төв ЭМГ
2	Хүүхдийн орыг нэмэх, бусад тасгийн үйл ажиллагааг түр зогсоон, хүүхдийн тусламж үйлчилгээнд шилжүүлж, хүүхдийн орыг 30-65 хувиар нэмэгдүүлэх	Тухай бүр	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд ЭМГ
3	Жирэмсний үзлэг хяналт, дархлаажуулалтын үйл ажиллагааг зохицуулах	Тухай бүр	Сум өрхийн эрүүл мэндийн төв БОЭТ
4	Үйлчлүүлэгч бүрт амны хаалт хэрэглүүлж хэвших	Тухай бүр	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд
Эрсдлийн харилцаа, холбоо			
1	Зөвлөгөө өгөх нээлттэй утас ажиллуулах	9 дүгээр сарын 15-аас	БОЭТ ЭМГ
2	ТТӨ-ий өнөөгийн байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээ, сэргийлэлтийн чиглэлээр гол мэдээллийг шинэчилж түгээх	Тухай бүр	ЭМГ, БОЭТ
IV ҮЕ ШАТ.ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ УЛСЫН ХЭМЖЭЭНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЕ /амбулаторийн үзлэг ТТӨ-ний 10000 хүн ам дах үзлэг <71-107/ Төлөвлөлт, зохицуулалт			
1	Орон нутгийн Засаг захиргааны байгууллагатай хамтран тархвар судлалын арга хэмжээ авах	Тухай бүр	ШУН, АЗДТГ ЭМГ, Сумын ЗДТГ, БСУГ
2	Өндөр настны тэтгэврийн эмч нарыг ӨЭМТ-ийн тусламж үйлчилгээнд дайчлан ажиллуулах	Тухай бүр	ЭМГ ӨЭМТ, СЭМТ

Тандалт, хяналт

		Тандалт, хяналт			
1	Хүүхдийн байгууллагыг түр хаах, үзвэр үйлчилгээ, нийтийн цуглааныг хязгаарлах арга хэмжэг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх	Шаардлагатай тохиолдолд	ШУН	ЗДТГ, ЭМГ	
2	Шаардлагатай тохиолдолд сумдад мэргэжлийн баг ажиллах	Шаардлагатай тохиолдолд	ЭМГ	ЗДТГ, БОЭТ	
Эмнэлгийн тусламж, үйлчилгээ					
1	Эмнэлэгт хэвтэх шалгуурыг нарийвчлан шаардлагагүй хэвтэлтийг багасгаж, эмнэлгээс гарсан, гэрээр эмчлэгдэж байгаа өвчтөний эмчийн хяналт, эргэлтийг эрчимжүүлнэ	Тухай бүр	БОЭТ, ӨЭМТ, СЭМТ		
2	Товлолын дархлаажуулалтын цагийн хуваарийг нөхцөл байдалтай уялдуулан зохицуулна.	Тухай бүр	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага		
3	Өрхийн эмчийн үзлэгийг гэрийн эргэлтэд бүрэн шилжүүлж, хөнгөн, дунд хэлбэрээр өвчилсөн тохиолдлыг гэрээр эмчилнэ.	Тухай бүр	БОЭТ, ӨЭМТ, СЭМТ		
Эрсдлийн үеийн харилцаа, холбоо					
1	Хүн амд чиглэсэн мэдээлэл сургалт, сурталчилгааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр өдөр бүр тогтмол хийх	Тухай бүр	ШУН, ЭМГ	Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, цахим хуудсууд	
2	ТТӨ-ий өнөөгийн байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээ, сэргийлэлтийн чиглэлээр гол мэдээллийг шинэчилж түгээх	7 хоног тутам	ШУН, ЭМГ	БОЭТ	
3	Ард иргэдэд зөвлөгөө өгөх нээлттэй утсыг 24 цагаар ажиллуулна.	Өдөр бүр	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага		
IV ҮЕ ШАТ.ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ТАХАЛТ ТАРХАЛТЫН ҮЕ /амбулаторийн үзлэгт ТТӨ-ний 10000 хүн ам дах үзлэг <108/ Төлөвлөлт, зохицуулалт					
1	Дэгдэлт болж буй суманд шуурхай хариу арга хэмжээний багийг томилон ажиллуулна.	Тухай бүр	ЭМГ	БОЭТ, ӨЭМТ	
2	Томуугийн харуулдан тандалтын нэгжүүдийн үйл ажиллагааг идэвхижүүлж, эрсдэлийн үнэлгээ хийх, эмнэлзүйн менежментийг сайжруулна.	Тухай бүр	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага		

3	Эрсдэлийн үнэлгээ, идэвхижлийн зэргээр ажиллах, шаардлагатай үед Аймгийн Онцгой комисс хуралдуулж, хөл хорио тогтоох асуудлыг шийдвэрлүүлнэ./үйлчилгээний байгууллагын цагийг богиносгох, хаах гэх мэт/, хязгаарлагдмал нөөцийг зөв хуваарилна /эм, тариа , хоол хүнс/	Тухай бүр	ЭМГ	АЗДТГ, БОЭТ
Эмнэлгийн тусламж үйлчилгээ				
1	Өвчтөнийг эрэмбэлэн ангилж, жирэмсний үзлэг, хяналт, бага насны хүүхдийн товлолын дархлаажуулалт зэрэг амбулаториор үзүүлэх тусламж үйлчилгээг өөр хэсэгт шилжүүлж, нягтралыг бууруулах	Тухай бүр	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	
2	Нөөц эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, суралцаж байгаа резидент эмч, төгсөх дамжааны оюутнуудыг дайчлан ажиллуулж, илүү цагийг тооцон шийдвэрлүүлнэ. /тэтгэвэрт гарсан эмч, сувилагч, эм зүйч г.м/	Тухай бүр	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага	
Эрсдлийн үеийн харилцаа, холбоо				
1	Өвчлөлийн байдалтай уялдуулан мэдээ, мэдээлэл, зөвлөмжийг боловсруулан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ард иргэдэд шуурхай түгээнэ.	Тухай бүр	ШУН, ЭМГ	БОЭТ
2	Үнэн зөв, бодит мэдээлэл сургалт сурталчилгааг цахимаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай түгээнэ.	Тухай бүр	ШУН, ЭМГ	БОЭТ

00000